

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ТАВДУГААР  
ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 12 дугаар сарын  
10-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

**Монголын Хуульчдын холбооны  
дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.1 дэх заалт, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэг, 9.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Хуульчдын Их хурлаас ТОГТООХ нь:

1. Монголын Хуульчдын холбооны дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолыг 20.. оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ИХ ХУРАЛ ДАРГАЛАГЧ

/

/

## **МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

**1 дүгээр зүйл.** Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.3, 4.5, 5.1, 8.16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалтуудыг нэмсүгэй:

1/ 4.3 дугаар зүйлийн 1.3 дахь заалт:

“Хуульчаар 3-аас доошгүй жил ажилласан байх;”

2/ 4.3 дугаар зүйлийн 1.4 дэх заалт:

“Сүүлийн гурван жил гишүүнчлэлтэй байсан сайн дурын зөвхөн нэг хорооноос нэрээ дэвшүүлсэн байх.”

3/ 4.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“Энэ зүйлийн 3-т заасны дагуу батламжлагдсан дараагийн гишүүний бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний үлдсэн бүрэн эрхийн хугацаатай адил байна.”

4/ 5.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“Ерөнхийлөгч сонгогдохдоо тодорхой мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн бол түүний биелэлтийг жил бүр Зөвлөлд тайлагнаж, дүнг Холбооны цахим хуудсанд байршуулан хуульчдад мэдээлнэ.”

5/ 8.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“Хороо үйл ажиллагаагаа хангалттай явуулахгүй байна гэж үзвэл тухайн хорооны нийт гишүүдийн 10-аас доошгүй хувь нь нэгдэн хорооны тэргүүн, удирдах зөвлөлийг тараах, чөлөөлөх саналыг холбооны Ерөнхийлөгчид гаргаж болох бөгөөд Ерөнхийлөгч үндэслэлтэй гэж үзвэл Зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “биечлэн” гэсний араас “,хурлын зард тусгайлан заасан бол цахимаар” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Монголын Хуульчдын холбооны дүрмийн доор дурдсан зүйл заалтыг дараах агуулгаар өөрчлөн найруулсугай.

1/ 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалт:

“тодорхой албан тушаал эрхэлж буй гишүүний хувьд олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулах;”

2/ 4.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“Зөвлөлийн тухайн жилийн нийт хурлын 50-аас дээш хувьд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй бол Зөвлөл уг гишүүнийг эгүүлэн татах шийдвэрийг гаргаж, энэ дүрмийн 4.5 дугаар зүйлийн 3-т заасны дагуу батламжлагдсан дараагийн гишүүнийг Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж, энэ тухай харьяалах хороонд мэдэгдэнэ.”

3/ 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.”

4/ 4.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.16 дахь заалт:

“Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх;”

5/ Дүрмийн 8.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“Хуульчдын холбоо нь нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудлаар сайн дураар нэгдэж байгуулсан хороотой байна.”

**4 дүгээр зүйл.** Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “1.8–д” гэснийг “1.7”, 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “шүүгч, прокурор, өмгөөлөгчөөс” гэснийг “хуульчдаас”, 7.6 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 болон энэ дүрмийн 7.2 дугаар зүйлийн 3-т” гэснийг “хууль тогтоомжид”, 8.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх...” гэснийг хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны”, 9.9 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийн “үндсэн заавар” гэснийг “нийтлэг журам” гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5 дахь заалтын “Мэргэжлийн хариуцлагын хорооноос бусад”, 8.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн “Мэргэжлийн хариуцлагын хорооноос бусад” гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.** Монголын Хуульчдын холбооны дүрмийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.4-т “Хуульчдын холбооны үйл ажиллагаанд оролцох, Хуульчдын холбооноос гишүүнийх нь хувьд хүлээлгэсэн, хуульд нийцсэн, мэргэжлийн үйл ажиллагаанд хамааралгүй үүрэг, даалгаврыг биелүүлэх;”, 2.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-т “Мэргэжлийн хариуцлагын хорооноос мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх хариуцлага хүлээлгэсэн;”, 2.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хорооноос хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх хариуцлага ногдуулсан хугацаанд гишүүний татвараас чөлөөлөхгүй.”, 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.5 дахь заалт “Мэргэжлийн хариуцлагын хороо байгуулж, бүрэлдэхүүнийг батламжлах, чөлөөлөх”, 3.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.3 дахь заалт “Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн 40 хувь нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон”, 4.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.20 дахь заалт “шүүгчид нэр дэвшигчийн талаарх дүгнэлтийг Хуульчийн мэргэжлийн

дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо (цаашид Ёс зүйн хороо гэх) болон Шалгалтын хорооны саналд үндэслэн гаргах;”, 4.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.22 дахь заалт “Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар Ёс зүйн хорооны саналыг хэлэлцэн шийдвэрлэх;”, 4.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.23 дахь заалт “Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар Шалгалтын хорооны саналыг хэлэлцэн шийдвэрлэх;”, 4.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.24 дахь заалт “Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журмыг батлах.”, 5.2 дугаар зүйлийн 1.6-д “Шүүгчдийн хорооны удирдах зөвлөлөөс өргөн мэдүүлсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээс ёс зүй, мэргэжлийн ур чадвар, хараат бусаар бие даан шийдвэр гаргах чадварыг шалгуур болгож, Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгох”, 8.1 дүгээр зүйлийн 1.1.Мэргэжлийн хариуцлагын хороо, 8.2 дугаар зүйл, 8.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 4.2 дугаар зүйлийн 2,3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Монголын Хуульчдын холбооны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ИХ ХУРАЛ ДАРГАЛАГЧ

/

/